



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.БАТБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

20200418 № 05/4358
танай _____-ны № _____-т


Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн авто үйлчилгээ, техникийн хяналтын үзлэгийн хяналт хариуцсан мэргэжилтэн болон автотээврийн хэрэгслийн бүртгэл, дугаарын үйлдвэрийн хяналт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хариуцсан шинжээчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Пунцаагийн Мөнхбат, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын автотээврийн хэрэгслийн ашиглалт үйлчилгээ хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Шолтайн Хавидолда, дотоодын ачаа, тээвэр хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Сумъяагийн Нансалмаа, Бодлого төлөвлөлтийн газрын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Доржийн Энх-Амгалан нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0006017